



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/383

Эрдэнэбулган сум

Сүрьеэ өвчний илрүүлэлт, оношлогоо,  
эмчилгээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолын зорилт 4-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүрьеэ өвчний илрүүлэлт, оношлогоо, эмчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангах, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сүрьеэ өвчний илрүүлэлт, оношлогоо, эмчилгээг зохион байгуулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сумдын Засаг дарга, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт, хэрэгжилтийн үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулахыг Эрүүл мэндийн газрын дарга /Р.Гандиймаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХНАСАН

351811216

Аймгийн Засаг даргын 2018 оны  
07 сарын 25 ны өдрийн 138 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Сүрьеэ өвчний илрүүлэлт, оношлогоо, эмчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангах, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Дарга: Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Нэгдсэн эмнэлгийн дарга

Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерийн зохицуулагч эмч

Сумдын Засаг дарга

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

Эрдэнэбулган сумын багийн нийгмийн ажилтнууд

Нарийн бичгийн

дарга: Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн



**СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ИЛРҮҮЛЭЛТ, ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Сүрьеэ өвчин нь дэлхийн олон улс оронд өвчлөл, эндэгдлийн зонхилох шалтгаан болсоор байгаа бөгөөд манай улс нь Номхон Далайн Баруун Бүсийн 37 орноос гуравт орж байна. Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд сүрьеэгийн нас баралтын тоо нэмэгдэж, жилд дунджаар 200 хүн амь насаа, хоёр мянган хүн хөдөлмөрийн чадвараа алдаж байгаа гэсэн харамсалтай тоо мэдээ гарсан байна.

Манай аймгийн хувьд 2017 оны жилийн эцсийн байдлаар халдварт өвчнөөр 491 хүн өвчилсний 10.4 хувь нь сүрьеэгээр өвчилсөн, сүүлийн 5 жилийн дунджаар 10,0 мянган хүн амд 7.2 тохиолдол бүртгэгдсэн байна. 2017 онд шинээр 51 тохиолдлыг илрүүлсэн бөгөөд эдгээр өвчтөний 70 гаруй хувь нь хөдөлмөрийн насны иргэд бүртгэгдэж, мөн эмэнд дасалтай сүрьеэгийн тохиолдлын тоо нэмэгдэж байна.

Сүрьеэгийн өвчлөлөөр аймгийн дунджаас 2.3 хувиар, улсын дунджаас 6.9 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

2017 оны байдлаар манай аймаг сүрьеэгээр өвчилсөн иргэдийн 91.3 хувийг эмчилсэн үр дүнтэй байгаа бөгөөд цаашид сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг илрүүлэх эмчлэх зайлшгүй шаардлагатай байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

1.Засаг даргын захирамжаар “Сүрьеэгүй аймаг” болох ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгйн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах

2. Засаг дарга, сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын хооронд байгуулах гэрээнд сүрьеэгийн асуудлыг 1 бүтээгдэхүүн болгон оруулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэх

3. Жил бүр 3-5 суманд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

1.Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах шийдвэр гаргагч нарт зориулсан сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдыг сургалтанд хамруулах

2. Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хангах

3. Жил бүр 3-5 суманд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, санхүүжилт болон зөөврийн рентген аппаратаар хангах асуудлыг шийдвэрлэх

4. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг сүрьеэгийн тусламж үйлчилгээ хэрхэн үзүүлсэн байдлаар үнэлж, урамшуулах

5. Иргэдийн эрүүл мэндийн хуудсанд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг оруулах

6. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх аян, компанит ажил зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

7. Сүрьеэгийн оношлогоо, эмчилгээний талаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхижуулах

8. Хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тогтмол зохион байгуулах

9. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтийг татан оролцуулах

#### АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

1. Сүрьеэгийн гаж нөлөөний эмийг жил бүр төсөвтөө тусгуулж, хэрэгжүүлэх

2. Сүрьеэгийн эмч, ажилчдын хүний нөөцийг нэмэгдүүлэх, эмч ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих, урамшуулал бий болгох

3. Сүрьеэгийн кабинетын агааржуулалтын системийг сайжруулах

4. Эмзэг бүлэг болон сүрьеэгийн хавьтлын судалгаа гаргаж, урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулах

5. Цэргийн насны залуучуудыг цэрэг татлагаас өмнө цээжний рентген зурагт хамруулах

6. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчдыг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах

7. Эмчилгээ хийлгэж буй өвчтөний эмчилгээний хяналтыг сайжруулах

#### СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

1. Түр оршин суугч, хаягийн бүртгэлгүй иргэдийн бүртгэл, хөдөлгөөнийг жил тутам хянаж, судалгааг нарийвчлан гаргах

2. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг хэрэгжүүлж ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг хагас бүтэн жилээр аймгийн ЗДТГ-т ирүүлэх

3. Сумын Засаг даргын сумын Эрүүл мэндийн төвийн дарга, багийн Засаг даргатай байгуулах гэрээнд 1 бүтээгдэхүүн болгон оруулж иргэдийг үзлэгт хамруулах, үүрэг чиглэл өгч ажлын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган хамтран ажиллах, дүгнэж урамшуулах, хариуцлага тооцох

4.Эмчилгээ тасалсан болон таслах эрсдэлтэй өвчтөнийг эмчилгээ таслахаас урьдчилан сэргийлэхэд багийн Засаг дарга, сайн дурын идэвхтэн, өрхийн эрүүл мэндийн төв, хорооны нийгмийн болон халамжийн ажилтнуудын хамтын ажиллагааг өрнүүлэн хамтран ажиллах

5.Амьжиргааны түвшин доогуур сүрьеэтэй өвчтөнийг унааны зардал, хоол хүнсээр хангахад дэмжлэг үзүүлэх

6.Архины хамааралтай өвчтөнийг эмчилгээ тасалдахаас урьдчилан сэргийлж, хэсгийн байцаагч нартай хамтран ажиллах

7.Сүрьеэгийн хавьтал болон эмзэг, эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг гарган, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах

8.Сүрьеэгээр өвчлөгсдийн сүүлийн 5 жилийн судалгааг газар зүйн байрлалаар гаргах

9.Сум, өрхийн эрүүл мэндийн төв, багийн Засаг даргын ажлын уялдаа холбоог сайжруулах

#### СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

1.Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн зохицуулагч эмч, мэргэжилтнүүдийг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлөөр хангаж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын үр дүнгээр нэмэлт урамшуулал олгох

2.Сум, өрхийн эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл тогтмол солилцох үйл ажиллагааг хэвшүүлэх

3.Сүрьеэгийн хавьтал болон эмзэг, эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг гарган, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох

4.Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хамтарсан багийг татан оролцуулах, хамтран ажиллах

5.Амбулаторит идэвхгүй үзлэгээр сүрьеэгийн сэжигтэй хүмүүсийг эрт илрүүлж дараагийн үзлэг шинжилгээнд цаг алдалгүй оруулах

6.Мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзлэгийг улирал тутам хийж, шаардлагатай бол 2 дахь шатлалд үзлэг, шинжилгээнд хамруулах

7.Ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг чанд барьж ажиллах, амбулаторит кварц тавих, ажилчдаа N95 маскаар хангах

8.Сорьц тээвэрлэлтийг графикийн дагуу чанартай гүйцэтгэх

9.Шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний хавьтлыг сумандаа 100 хувь анхан шатны үзлэг, шинжилгээнд хамруулах